

АГУУЛГА

1. Төслийн товч танилцуулга.....	2
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	2
2.1 Төслийн байршил.....	2
2.2 Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал.....	2
2.3 Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал.....	3
3. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл.....	4
4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.....	5
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	5
6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	8
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	8
8. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	9
9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	11
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	12
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	14
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	15

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** “Багануур дүүргийн ус хангамж, ариутгах татуургын байгууламж”-ийн төсөл

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Багануур-Ус” ААТҮГ

Улсын бүртгэлийн дугаар: 2714001002

Регистрийн дугаар: 2008815

Хаяг: Улаанбаатар, Багануур дүүрэг 5-р хороо,  
залуус хэсэг /12100/ залуусын, 45/1

Утас: 70210141,99000546,

## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**2.1 Төслийн байршил:** Багануур-Ус ААТҮГ нь 1982 оны 7 дугаар сард Сайд нарын зөвлөлийн 56 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдаж 42 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Өнөөгийн байдлаар Багануур дүүргийн 8500 орчим орон сууц, гэр хорооллын айл өрх, 31 төсөвт байгууллага 80 орчим үйлдвэр, үйлчилгээний газар, аж ахуйн нэгжийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ эрхэлдэг. Энэхүү төсөлд Багануур-Ус ААТҮГ-ын “Усан хангамж, ариутгах татуургын барилга байгууламж” хамаарч байна. Ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгууд болон Хэрлэн станц нь Багануур дүүргийн төвөөс зүүн урд зүгт 10км-т Багануур дүүргийн 4-р хороонд, харин Наран станц, И станц болон цэвэрлэх байгууламжийн барилга, бохирын станц нь Багануур дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг.

Нийслэлийн Багануур дүүрэг нь Улаанбаатар хотоос зүүн тийш 130 км зайд Хэрлэн голын сав газарт оршдог. Монгол улсын нийслэлийн алслагдсан дүүрэг юм. БНМАУ-ын АИХТ-ийн 1980 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 43 дугаар зарлигаар Улаанбаатар хотын Багануур район нэртэйгээр байгуулагдсан. Хан Хэнтийн нуруунаас эх авсан Хэрлэн гол тус дүүргийн нутаг дэвсгэрээр 14 км урсан өнгөрдөг.

### 2.2 Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал

**Физик газарзүйн нөхцөл:** Багануур дүүргийн нутаг дэвсгэр нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт байрлана. Хэнтийн уулт мужийг гадаргын байдлаар уулархаг хэсэг, талархаг ба цав толгодот хэсэг гэж 2 ангилж дотор нь районуудыг ялган тогтоосон байдаг. Хэрлэн орчмын хэвгий талын район нь Хэрлэн голын дагуу нилээд газрыг хамрах бөгөөд өргөн нь хэдэн зуун метрээс хэдэн арван км хүрнэ. Гадаргын байдал ерөнхийдөө налуу боловч уулсаас буух түр урсгалаар бас нилээд хэрчигдсэн байна. Гадаргад нь нам уулс, цав толгод, ухаа гувээт тал, хуримтлалын тал зонхилно.

Багануур дүүрэг нь засаг захиргааны нэгжээр Улаанбаатар хотын алслагдмал дүүрэг боловч, нутаг дэвсгэрийн хувьд Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг дэвсгэрт зүүн талаараа Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумтай залгаа байрладаг.

Уур амьсгалын тойм: Багануур дүүргийн нутаг дэвсгэр нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт байрлах ба уур амьсгалын хувьд чийглэгдүү хүйтэвтэр мужид оршино. Багануур дүүргийн нутаг дэвсгэрт агаарын температурын жилийн дундаж утга (ЖДУ)  $-2.2^{\circ}\text{C}$  (хүснэгт 24) байна.

- Агаарын температур: Өвлийн улиралд Багануурт сарын дундаж агаарын температур  $-19.8^{\circ}\text{C}$ -аас  $-25.2^{\circ}\text{C}$ , зуны улиралд  $15^{\circ}\text{C}$ -аас  $17.4^{\circ}\text{C}$ -ын хооронд хэлбэлзэнэ. Багануур дүүрэгт агаарын хамгийн их температур  $37.2^{\circ}\text{C}$  2010 оны 7 сарын 24-нд, хамгийн бага буюу хүйтэн температур  $-47.9^{\circ}\text{C}$  2001 оны 1 сарын 9-нд тус тус тэмдэглэгдсэн байна. Тус нутаг дэвсгэрт  $-30^{\circ}\text{C}$ -аас давж хүйтрэх өдрийн тоо жилд 40-50 байдаг бол  $30^{\circ}\text{C}$ -аас давж халах өдрийн тоо 10-20 байна.
- Салхины чиглэл. хурд: Багануур дүүрэгт жилийн дундаж салхины хурд 2-6 м/сек байдаг. Өвөлдөө салхины чиг зүүн хойноос байх ба намар болон хавартаа салхины хурд хамгийн их, салхины хамгийн их дундаж хурд нь 24-25 м/сек байх ба салхины хурд нь 15 м/сек-ээс дээш байдаг өдрийн тоо нь олон жилийн дунджаар 23 өдөр. Монгол орны бүхий л нутгуудад хойд (Х) болон баруун хойд (БХ) зүгээс салхилах салхины давтагдал хамгийн их байдаг онцлогтой. Энэ ерөнхий зүй тогтолын дагуу хойд (Х) зүгээс салхилах салхины давтагдал Багануурт 27.1%, баруун хойноос (БХ) салхилах салхины давтагдал Багануурт 7.5% байдаг. Зүүн хойд (ЗХ) зүгээс салхилах салхины давтагдал Багануурт 16.5% байгаа нь бусад цэгүүдтэй харьцуулахад бараг 2-4 дахин их байдаг онцлогтой. Баруун өмнөөс (БӨ) салхилах салхины давтагдал Багануур орчимд 10.3% байна. Салхины хамгийн сул хүч 6-р сард, эрчимжилт ихтэй үе нь 4, 5 сарууд байна.
- Хур тунадас: Багануур орчим жилд дунджаар 220 мм тунадас ордог бөгөөд, сүүлийн 21 жилд дунджаар 136-286 мм тунадас орсон байна. 2009-2014 оны дулааны улиралд халалтаас үүдэн аадар тунадасны давтамж ихэссэнтэй холбоотойгоор тунадасны хэмжээ ихсэх хандлагатай байна. Хур тунадасны 88% нь дулааны улиралд, 12% нь өвлийн улиралд ихэвчлэн ордог. Хоногт орсон хамгийн их хур тунадас 57.8 мм 2015 оны 8 сарын 4-нд Багануурт орж байсан байна.
- Агаарын даралт. нарны цацраг: Агаарын даралт 844-846 гПа-д хэлбэлзэх ба нар гийгүүлэх хугацаа жилд 2700-2800 цаг. Нарны нийлбэр цацраг 1200-1300 кв.цаг/м<sup>2</sup>. Бүрхэг байх өдрийн тоо жилд 50-70 өдөр, цэлмэг байх өдрийн тоо 60- 100 өдөр байна.

### **2.3. Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал**

Багануур дүүрэг нь Улаанбаатар хотын есөн дүүргийн 1 бөгөөд алслагдмал зүүн тийш 130 км зайд Улаанбаатар хотоос Хэнтий аймаг явах төв зам дагуу байрладаг. Нийт 62.2 мянган га газар нутагтай, засаг захиргааны 5

хороотой. Тухайн үедээ 599.8 сая тоннын нөөцтэй гэж тогтоогдож байсан Багануурын нүүрсний уурхайг 1973 онд олборлож эхэлсэн ба энэхүү нүүрсний ордыг түшиглэн 1980 онд Багануур дүүргийг байгуулжээ. Дүүргийн нийт нутаг дэвсгэрийн 41.6 мян.га нь ХАА-н, 19.3 мян.га хот суурин, 4.71 га зам шугам сүлжээ, 14.26 га улсын тусгай хэрэгцээний, бусад ойн болон усны сан бүхий газар эзэлдэг.

Монгол улсын төв болон зүүн бүсийг холбосон авто зам дайран өнгөрдөг, олон улсын төмөр замын сүлжээнд холбогдсон. Мөн Монгол улсын зүүн хэсгийг холбосон эрчим хүчний сүлжээний хуваарилах төвтэй. Багануур дүүрэг нь Монгол улсын эдийн засгийн Төвийн бүс, Зүүн бүсийн зааг дээр оршдог тул нийгэм, эдийн засгийн нэг гол зангилаа болон хөгжих боломжтой юм. Багануур дүүргийн суурьшлын бүсээс харахад хойд хэсгээрээ гэр хороолол суурьшсан, дунд хэсэгт барилгажсан хэсэг ба хотын төв, өмнөд хэсэгтээ буюу замын урд талд Багануурын уурхайн эдэлбэр, үйлдвэрүүд байршдаг.

Багануур дүүргийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2030 төлөвлөгдсөнөөр Багануур хотын шинэ төв болон Багануур үйлдвэр технологийн парк төлөвлөгдсөн.

### **3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

- Ус хангамжийн системийн хувьд нөлөөлөлд хамгийн их өртөгч нь хөрсөн бүрхэвч, газрын гадаргын элэгдэл, эвдрэл, ургамал бүрхэвч, газрын доорх усны чанар бол бага нөлөөлөлд агаарын чанар, дуу чимээ, ажиллагсад болон нөлөөллийн бүсийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, мал амьтан байна.
- Бохир ус татан зайлуулах системийн хувьд нөлөөлөлд хамгийн их өртөгч нь агаарын чанар, газар доорх усны чанар, хөрсөн бүрхэвч, газрын гадаргын элэгдэл эвдрэл, бохирдол байсан бол дунд нөлөөлөлд гадаргын усны чанар, ургамлан нөмрөг, ажиллагсдын болон орчны бүсийн иргэдийн эрүүл мэнд, бага нөлөөлөлд дуу чимээ, мал амьтан, газрын хэвлий, геологийн тогтоц байна.

Дээр тодорхойлсон болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн үнэлгээнээс дүгнэхэд ус хангамжийн системийн хувьд газрын гадарга талхлагдах, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг усаар элэгдэх, хүний, техникийн нөлөөллөөр элэгдэл, эвдрэлд, өөрчлөлт орж байна. Мөн хүн амын өсөн нэмэгдэх ус хэрэглээнээс ус хангамжийн эх үүсвэрийн нөөц багасах, нөөцийг дахин тогтоолгох асуудал тулгарч байна. Харин ариутгах татуургын хувьд цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшингээр шууд хамааралтай байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт нөлөөлөл үзүүлнэ. Хамгийн ихээр өртөгч нь агаар орчин, хөрсөн бүрхэвч байна. Тухайлбал,

бохир ус татан зайлуулах үйл ажиллагаа хэвийн бус явагдсанаар агаар орчинд таагүй үнэр гарах, агаар дахь бохирдуулагч бодисын агууламж нэмэгдэх, хөрс микробиологи нянгийн бохирдлоор бохирдох, улмаар хүрээлэн буй орчныг бохирдуулах зэрэг шууд бөгөөд гол нөлөөллүүд байна.

#### **4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино. Үүнд:

- Ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- БОННҮнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,

Багануур-Ус ААТҮГ-ын “Ус хангамж, ариутгах татуургын байгууламж” төслийн 2021- 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29 өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

#### **5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025**

	<b>Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд</b>	<b>Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ</b>	<b>Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ</b>	<b>Хэмжих нэгж, тоо хэмжээ</b>	<b>Нэгжийн зардал (төгрөг)</b>	<b>Нийт зардал, төг</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа, давтамж</b>	<b>Баримтлах эрх зүйн баримт бичиг</b>
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>
<b>Ус хангамжийн систем</b>								
1	Газрын доорх усны чанар алдагдах, хүн амын ундны усны чанар, аюулгүй байдал	Ундны усны эх үүсвэрт газрын доорх усны түвшин, усны чанарыг байнга хянах мониторингийн цооног байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээллийн санд бүртгүүлэх	Ус хангамжийн эх үүсвэр	1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		2025 он	Усны тухай хууль
2	Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн дэглэм зөрчигдөх	Усан хангамжийн эх үүсвэрийн онцгой болон хязгаарлалтын бүсийн дэглэмийг мөрдөх, тогтоосон бүсийн хилээр хашааг татах	Ус хангамжийн эх үүсвэр	1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		2025 он	Усны тухай хууль 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаал
		Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд тэмдэг, тэмдэглэгээг байршуулах	Ус хангамжийн эх үүсвэр, Хэрлэн гол	1-2 удаа	200000		2025 он	Усны тухай хууль
3	Усаар хангах үйлчилгээ муу байх	Ухаалаг ус түгээх байрнуудын үйлчилгээг сайжруулах	24-н УТБ		Үйл ажиллагааны зардалд тусгах		2025 он	Усны тухай хууль
4	Усны чанар алдагдах	Усны лабораторид усны чанарыг шалгах шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг суурилуулан ашиглах. Тухайлбал, цэвэр усанд нитрат, хуурай үлдэгдэл үзэх Усан банн, цэвэр усны булингар тодорхойлох Турбидометр болон Аналитик жин зэрэг	Дотоод хяналтын лаборатори	удаа	Үйл ажиллагааны зардал тусгах		2025 он	-

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025**

5	Усны алдагдал	Цэвэр усны шугам сүлжээний засвар үйлчилгээг тогтмол хийх	Төлөвлөгөөт ажлын хүрээнд	тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгах		2025 он	Усны тухай хууль БНБД 40-04-16
6	Усны алдагдал, замбараагүй хэрэглээ	Хэрэглэгчдэд усыг зөв хэрэглэх дадал заншлыг эзэмшүүлэх сургалт сурталчилгааг явуулах	Айл өрх, ААНБ	1-2 удаа	200000	200000	2025	Усны тухай хууль
		Хэрэглэгчдийг тоолууржуулах ажлыг үргэлжлүүлэх		тогтмол			2025	Усны тухай хууль 2013 оны А/156 дугаар тушаал
		Сэтгэл ханамжийн судалгаа авах,		2 удаа	100000	200000	2025	Байгууллагын дүрэм, журамын дагуу
<b>Ариутгах татуургын систем</b>								
<b>Хөрсөн бүрхэвч, ургамал нөмрөг</b>								
7	Цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагаа алдагдах, технологийн бус горимоор ажилласнаас бохир ус хөрсөнд хаягдах	Хэрэглэгчдээс ирж буй бохир усыг технологийн дагуу цэвэрлэж, стандартын шаардлагыгхангасан хаягдал усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэх, цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг байнга хянах	Бохир ус Цэвэрлэгдсэн хаягдал ус	Тогтмол /өдөр бүр/	Үйл ажиллагааны зардалд тусгах		2025 он	MNS4943;2015
8	Үйл ажиллагааны явцад тоног төхөөрөмж, шугам хоолойд засвар үйлчилгээ хийгдэх явцад газрын гадарга элэгдэл эвдрэлд өртөж, хөрс, ургамлан нөмрөг талхлагдаж болзошгүй	Инженерийн шугам сүлжээнд урсгал болон их засвар үйлчилгээ хийх, өргөтгөл шинэчлэл хийх үед эвдрэл өртсөн газрыг тухай бүр шимт хөрсөөр эргүүлэн хучиж, нөхөн сэргээх шаардлагатай.	Цэвэр, бохир усны шугам хоолой,хоёр тийш 5 м	Тухай бүр	-		2025 он	MNS5916:2008 MNS5918:2008

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025**

9	Хөрсний бохирдол	Төслийн явцад хөрсөнд бохирдол үүссэн эсэхийг хянах мониторингийн цэг тогтоох, бохирдол илэрсэн тохиолдолд түүнийг саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээг нэн даруй авах	Цэвэрлэх байгууламж, бохир соруулах явцад	Тухай бүр	Үйл ажиллагааны зардалд		2025 он	MNS 5850:2019 MNS 6341:2012
		Технологийн хаягдлын үлдэгдэл бохирдлыг саармагжуулах (Үнэр арилгагч бэлдмэл ашиглана)	Элсний талбай Лагийн талбай	Шаардлагатай хэмжээг эр	1кг-6000	600000	2025 он	
<i>Агаар орчин</i>								
10	Дуу шуугиан, Физик бохирдол үүсэх	Дотоод орчны температур, чийг, дуу шуугиан хэмжигч суурилуулах	Цэвэрлэх байгууламжийн дотоод орчин	Тус бүр 1 ш	500000	500000	2025 он	MNS4585:2016
<i>Гадаргын болон газрын доорх ус</i>								
11	Цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал ус нь стандартын шаардлага хангаагүйгээс голын усыг бохирдуулах	Хүлээн авсан бохир усыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэх, технологийн горимд тогтмол хяналт тавих	ЦБ-ын технологийн горим, цэвэрлэсэн хаягдал ус	тогтмол	Үйл ажиллагааны зардал		2025	MNS4943;2015 MNS6561;2015
		ЦБ-д нийлүүлэгдэж байгаа бохир ус болон хаягдал усны шинжилгээг дотоодын лабораторид тогтмол хянах	ЦБ-ын өдөр тутмын үйл ажиллагаа	7 хоногт 3-н удаа			2025	MNS ISO 5667-10;2001
12	Газрын доорх ус бохирдох	Ариутгах татуургын шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг шалгах	34,7м шугам хоолой	Тухай бүр			2025	БНБД
13	Бохир усны сүлжээ бөглөрөх	Бохир усны худаг шугам, хаалт тоноглолд төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийх	ЦБ-ын худаг шугам	Жилд 2 удаа			2025	MNS4943;2015
14	Бохир усны шүүрэлт, гоожилт явагдах	Тоног төхөөрөмжийн битүүмжлэл, үйл ажиллагааны горимыг чанд биелүүлж, шугам хоолойн холбоосны	Цэвэрлэх байгууламжийн дотоод үйл	Тогтмол			2025 он	MNS4943;2015



**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025**

		битүүмжлэлийг хангах	ажиллагаа					
<b>Ургамал, амьтан</b>								
15	Мал, амьтан бохир усаар дамжин халдварт өвчнөөр халдварлах, улмаар хүн халдварлах	Цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал усны ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Халдваргүйжүүлэх төхөөрөмж /хлор/	15кг/өдөр /хоолны давс/	1кг-1000	5400000	2025	
16	Ургамлан нөмрөг халцрах	Цэвэрлэх байгууламжийн барилгын гаднах сул талбайг ургамалжуулан ногоон байгууламж бий болгох, арчилан тордох	сул талбай	Зүлэг,суулгац суулгана.	Нөхөн сэргээлтийн зардалд тусгасан		2025	MNS5914:2008 MNS5918:2008
<b>1 жилийн нийт зардал, төгрөг</b>						<b>7100000</b>		

**6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Цэвэрлэх байгууламжийн барилгын гаднах сул талбайг ургамалжуулан ногоон байгууламж бий болгох	Мод, зүлэг тарих	Сул талбай	ш	Шар хуйс-10ш, зүлэг-5кг	8500 60000	385000	2025	Нөхөн сэргээлт
2	Орчны тохижилт, ногоон байгууламж байгуулах	Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд мод тарих	Сул талбайд	ш	300	5000	1500000	2025	Тэрбум мод хөтөлбөр
<b>1 жилийн нийт зардал, төгрөг</b>							<b>1885000</b>		

**7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Багануур-Ус ААТҮГ-ын “Ус хангамж. ариутгах татуургын байгууламж”-ийн төслөөс түүх, соёлын өв, Багануур дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн 76 тооны дурсгалд үзүүлэх нөлөөлөл байхгүй. Иймээс түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзэв.

**8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
<b>Химийн бодисын тээвэрлэлт</b>								
1	Химийн бодис асгарах алдагдах, байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр цар хүрээ тэлэх	Химийн бодисыг зориулалтын тээврийн хэрэгсэлээр аюулгүй тээвэрлэх	Химийн бодис тээвэрлэх зам	Хэрэглээн ээс хамаарна	Үйл ажиллагааны зардал		2025	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам. MNS4978;2017
<b>Химийн бодисын хадгалалт, ашиглалт</b>								
2	Химийн бодис хадгалалт ашиглалтын явцад асгарах, хөдөлмөр хамгааллын дүрэм алдагдаснаар ажилтнуудын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх	Химийн бодистой харьцаж ажиллах ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангах	Дотоод хяналтын лабораторийн нийт ажилчид	5-н хүн	ХАБЭА-н зардалд тусгах		2025	MNS ISO 13688;2000
		Химийн бодистой харьцаж ажиллах		Жилд 2 удаа			100000	200000

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025**

		зааварчилгаа, сургалтыг явуулах						
<b>Химийн бодисын сав баглаа боодол устгах</b>								
3	Химийн бодисын сав баглаа боодлыг зориулалтын бус газар хадгалснаар усаар угаагдах, хөрсөнд нэвчих, орчныг бохирдуулах эрсдэлтэй	Химийн бодисын савыг саармагжуулах, тусгай шүүгээнд аюулгүй түр хадгалах	Лабораторийн өрөө	тогтмол	300000	300000	2025	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам. Дугаар54/А/136/А/215
4	Химийн бодисын хольц хаягдал нь бохирдлын эх үүсвэр болох	Лабораторийн шинжилгээнээс гарах химийн бодисын хольц хаягдалыг зайлуулах	Тусгай хог хаягдал	Гэрээнд заасан хугацаанд	Үйл ажиллагааны зардал		2025	
<b>Ослын эрсдэлээс урьдчилан сэргийлэх</b>								
5	Химийн бодисын агуулахын битүүмж алдагдаж агаар, ус, хөрсөөр тархах. Химийн бодисын ашиглалтын үед асгарч алдагдах	Химийн бодист өртсөн үед яаралтай тусламж үзүүлэх хэрэгсэл, эмийн санг тодорхой газарт байрлуулах, тогтмол сэлбэж шинэчлэх	Хувцас солих өрөө	2ш	100000	200000	2024	Гамшигаас хамгаалах тухай хууль
		Химийн бодисын агуулах болон лабораторийн өрөөний шал, тааз, агааржуулалтын системд хяналт тавьж эвдрэл гарсан тохиолдолд засах	Агааржуулалтын систем	тогтмол	Үйл ажиллагааны зардал		2025	

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025**

6	Химийн бодисын агуулах болон лабораторид гал гарах	Галын аюулаас сэргийлэх зорилгоор галын хор, асгаралтын иж бүрдлээр бүрэн хангах, хугацаа дууссан үед шинэчлэх	Химийн бодисын агуулах, лабораторийн өрөө	Иж бүрдэл	800000	800000	2025	Галын аюулаас урьдчилан сэргийлэх заавар
7	Химийн бодисын зөвшөөрөлгүй ажиллах	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл авах	Багануур-Ус ААТҮГ	Жилд 1 удаа			2025	Химийн хорт болон аюултай бодисын тухай
8	Химийн бодисыг тооцоогүй ашиглах, химийн бодис алдагдах	Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтөлж, холбогдох байгууллагад тайлагнах	Ашиглаж буй химийн бодис тус бүрээр	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал		2025	Химийн хорт болон аюултай бодисын тухай
<b>1 жилийн нийт зардал, төгрөг</b>						<b>1500000</b>		

**9. ХОГ, ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ, хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	7	8	9
1	Ахуйн	Хог хаягдал ачиж, зайлуулах гэрээг орон нутгийн эрх бүхий байгууллагатай шинэчлэн хийх. Хог хаягдал зайлуулсан бүртгэл хөтөлөн ажиллах	Хог хаягдал	Сар бүр	Гэрээний дагуу		2025	Хог хаягдалын тухай хууль
		Ахуйн хог хаягдлыг түр хадгалах цэг, хогийн савыг сайжруулах, нэмэлтээр	Цэвэрлэх байгууламжийн барилгын гадна талд	ш	1000000	2025		

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025**

		байршуулах						
		Хог хаягдалын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх	Ахуйн хог хаягдал	Сар бүр	75000	900000	2025	
		Нийтийг хамарсан цэвэрлэгээ, зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох, арга хэмжээг зохион байгуулах	Нийтийн эзэмшлийн зам талбай	Улирал бүр			2025	
2	Үйлдвэрийн	Сараалжаас гарсан хаягдалыг ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, хуурайшуулан, төвлөрсөн хогийн цэгт зайлуулсан бүртгэл хөтлөх	Цэвэрлэх байгууламж, насос станц	тогтмол	Үйл ажиллагааны зардал		2025	MNS4585;2016 Хог хаягдалыг тухай хууль
		Хаягдалыг байгальд халгүй аргаар зайлуулах, тоо бүртгэлийг байнга хөтлөх	Ахуйн болон технологийн хаягдал	Сар бүр	Үйл ажиллагааны зардал		2025	
		Ус зайлуулах шугам хоолойгоор дамжих хог бохирдолыг багасгах, ЦБ дээр ирэх ачааллыг бууруулахын тулд дүүргийн хэмжээнд хог хаягдалыг ангилан хаях дадлыг сайжруулах арга хэмжээ авах	Нөлөөллийн бүсийн оршин суугч	2 удаа	200000	400000	2025	Хог хаягдалын тухай хууль ЗГ-ын 2015 оны 264-р тогтоолын хавсралт
3	Аюултай	Аюултай хог хаягдалыг тусгай цэгт хадгалах, хаягжуулах бүртгэл хөтлөх	Аюултай хог хаягдал	тн	Үйл ажиллагааны зардал		2025	
		Аюултай хог хаягдалыг эх үүсвэр дээр бууруулахад анхаарах, химийн бодисын хаягдалыг эх үүсвэр дээр саармагжуулж зайлуулах	Аюултай хог хаягдал	тн			2025	
		Аюултай хог хаягдалыг байгальд халгүй аргаар зайлуулах, бүртгэл хөтлөх	Аюултай хог хаягдал	Улирал бүр			2025	
<b>1 жилийн нийт зардал, төгрөг</b>					<b>2300000</b>			

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
<b>Дотоод хяналт шинжилгээ</b>								
1	Цэвэр усны хими, физикийн үзүүлэлт, бактерлогийн үзүүлэлт	Гүний худаг-4 Хэрлэн станц Наран станц УДДТ-4 УТБ-28 Нийт 38 цэгт	Сар бүр	1		Үйл ажиллагааны зардал	Өөрийн итгэмжлэгдсэн лабораторид Өөрийн итгэмжлэгдсэн лабораторид	MNS0900;2018
2	Бохир усны химийн үзүүлэлт,	Нийт 4 цэгт	7 хоног бүр	3				MNS4943:2015
3	Цэвэрлэгээний түвшин	Цэвэрлэх байгууламж	7 хоног бүр	3				
4	Лагийн шинжилгээ	Аэротенк	7 хоног бүр	3				
5	Нян судлалын шинжилгээ	2-р тунгаагч хаялтын шугам	7 хоног бүр	1				
<b>Хөндлөнгийн хяналт шинжилгээ: Агаар</b>								
1	Хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос тоосонцор	ЦБ-с зонхилох салхины доор 200м-ын радиус дотор 1 цэгт	Жилд	2	100000	200000		MNS4585:2016
2	Дуу чимээ	Цэвэрлэх байгууламжийн дотоод орчинд 1 цэгт	Жилд	2	120000	480000	Байнгын хэмжих багаж, суурилуулах	MNS4585 : 2016 MNS4990:2015 MNS5002:2000
<b>Хөрсний бохирдол</b>								
3	Хөрсний агрохимийн үзүүлэлт	Тунгаагчын орчим, хаягдал ус гаргалгааны орчим. Нийт 2 цэгт	Жилд	1	55000	220000	Шинжилгээний үр дүнгээс хамаарч давтамжийн тоог нэмэгдүүлнэ	MNS3310;1991 MNS ISO10390;2001
4	Хөрсний хүнд металын бохирдол	Технологийн хаягдалын орчим,	Жилд	2	65000	390000		MNS5850;2019 MNS ISO

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025**

		шүүрүүлэх карт, цэвэрлэсэн хаягдал усны гаргалгаа орчим. Нийт 3 цэгт						11466;2007
5	Микробиологийн бохирдол	Технологийн хаягдалын орчим, шүүрүүлэх карт, цэвэрлэсэн хаягдал усны гаргалгаа орчимд. Нийт 2-3 цэгт	жилд	2	55000	330000	Шинжилгээний үр дүнгээс хамаарч давтамжийн тоог нэмэгдүүлнэ	MNS6341;2012 MNS5367;2004
<b>Усны чанар</b>								
6	Цэвэр усны хими, физикийн үзүүлэлт	Гүний худгууд, өргөлтийн станцууд, УТБ-ууд. Нийт 10 цэгт	жилд	1	60000	600000	Шинжилгээний үр дүнгээс хамаарч давтамжийн тоог нэмэгдүүлнэ	MNS0900;2018
7	Цэвэр усны хими, физикийн үзүүлэлт	Хэрлэн голд	жилд	1	60000	60000		MNS4586;1998
8	Хүнд металлын үзүүлэлт	Гүний худаг, өргөлтийн станц, УТБ-ууд. Нийт 6 цэгт	жилд	1	55000	330000		MNS0900;2018
9	Бохир усны химийн үзүүлэлт	Цэвэрлэх байгууламжийн оролт, гаралт. Нийт 2 цэгт	жилд	4	68000	544000	Улирал бүр хөндлөнгийн шинжилгээ хийлгэх	MNS6561;2015
10	Хүнд металлын үзүүлэлт	Цэвэрлэсэн хаягдал уснаас	жилд	1	78000	78000	Шинжилгээний үр дүнгээс хамаарч давтамжийн тоог нэмэгдүүлнэ	MNS0900;2018 MNS ISO11885;2011
<b>1 жилийн нийт зардал</b>						<b>3232000</b>		

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024он /улирал/					
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал		
1	2	3	4	5	6	7	8	
1	Төслийн үйл ажиллагаа онцлогт тохируулан ХАБЭА болон байгаль орчны бодлого дүрэм журмыг боловсруулан ажилчдад хэвшүүлэх	-	Боловсруулах	Хэрэгжүүлэх, уяалдаа холбоог сайжруулах			Багануур-Ус ААТҮГ-ын дарга, инженерүүд	Тогтмол сайжруулах
2	ХАБЭА болон БО хариуцсан мэргэжилтэнийг авч ажиллуулах эсвэл уг мэргэжилтэй холбоотой өөр ажилтанд хариуцуулан ажиллах					Багануур-Ус ААТҮГ-ын хариуцсан албан тушаалтан	Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох стандарт шаардлагын дагуу	
3	Жил бүрийн БОМТ-г боловсруулан холбогдох газруудаар батлуулан, хэрэгжүүлэх					Багануур-Ус ААТҮГ-ын хариуцсан албан тушаалтан	БОАЖ-ын сайдын А/618 журамд заасан хугацаа, шаардлагын дагуу	
<b>1 жилийн нийт зардал, төгрөг</b>		-						



**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025**

**12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль орчин аялал жуулчлалын яам	Тайланг хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт хүргүүлнэ	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан, Дараа жилийн БОМТ-г хяналтын хуудсын хамт	12 сарын 10-ны дотор	100000	Багануур-Ус ААТҮГ-ын хариуцсан албан тушаалтан, төлөөлөл	Улаанбаатар хот
2	Нийслэлийн байгаль орчны газар	Тайланг хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт хүргүүлнэ	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	11 сарын 01-ний дотор	100000	Багануур-Ус ААТҮГ-ын хариуцсан албан тушаалтан, төлөөлөл	Улаанбаатар хот
3	Нийслэлийн Засаг даргын томилсон ажлын хэсэг	Газар дээр дүгнэнэ.	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн талаар танилцуулна.	11 сарын 30-ны дотор	300000	Багануур-Ус ААТҮГ-ын удирдлага	Багануур дүүрэг
<b>1 жилийн нийт зардал</b>					<b>500000</b>		